

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ӨРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: Бусад 2023 оны А/305-р тушаал

Дагаж мөрдөх огноо: 2024.09.05

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2024.09.05

Байгууллагын нэр:

Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Нэгжийн нэр:

Ариутгал халдваргүйтгэл, био-үйлдвэрлэлийн алба

Албан тушаалын нэр:

Лаборант

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮЭМ-4

Ажлын цаг:

6 цаг (8³⁰-15³⁰)

Ажлын байрны албан ёсны байршил:

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн өөрийн байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн бус

Онцгой нөхцөл:

Хортой

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Био бэлдмэл, тэжээлт орчин, будаг урвалж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах бэлтгэл хангах, нян залгиур үйлдвэрлэлд оролцох

Албан тушаалын зорилт:

- Лабораторийн шинжилгээ судалгааны ажлын захиалгын дагуу Био бэлдмэл, ялган оношилох тэжээлт орчинг савлан нийлүүлэх.
- Хүний өвчлөлийн тохиолдол, мэрэгч амьтны дуудлага, лабораторийн яаралтай шинжилгээний ажилд шаардлагатай ялган оношлох тэжээлт орчинг технологичийн хамт үйлдвэрлэн савлан нийлүүлэх
- Тэжээлт орчин, будаг урвалж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах бэлтгэл хангах, үндсэн түүхий эд бэлтгэх, тэжээлт орчин үйлдвэрлэхэд ашиглагдсан химийн шил сав, хувин тогоо шүлтийн даавууг угааж үйлдвэрлэл эхлэхэд бэлэн болгох
- Үйлдвэрлэсэн тэжээлт орчин, будаг урвалж уусмал, будаг шингээсэн цаасны нөөц, бараа материалын захиалга гаргах, үйл ажиллагааны тоон мэдээг үнэн зөв гаргах, АШБМаягтуудыг хөтлөх
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх
- Байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэ-лийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	- Оношилгооны бактериофаг үйлдвэрлэх бэлтгэл ажлыг бүрэн хангаж технологичийн хамт үйлдвэрлэх - Төвийн лабораториудын захиалгын дагуу чанарын шаардлага хангасан ялган оношлох тэжээлт орчин, будаг урвалж, уусмалуудыг савлан нийлүүлэх. - ЗӨСТөвүүдийн захиалгын дагуу чанарын шаардлага хангасан үндсэн болон ялган оношлох тэжээлт орчин, будаг урвалж, уусмал, будаг шингээсэн цаасыг савлан боож бэлтгэн нийлүүлэх	Технологи заавар, фармакопей Захиалга нийлүүлэлт чанар Нийлүүлсэн тоо хэмжээ	Т Т Т
2 дугаар зорилтын хүрээнд	- Хүний өвчлөлийн тохиолдол, мэрэгч амьтны дуудлагад лабораторийн яаралтай шинжилгээний ажилд шаардлагатай ялган оношлох тэжээлт орчинг захиалгын дагуу технологичийн хамт үйлдвэрлэх - Фирмийн бэлэн, ялган оношлох тэжээлт орчныг савлан нийлүүлэх, зарим төрлийн нэмэлттэй тэжээлт орчныг лабораторид бэлтгэж савлах. - Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг боож бэлтгэн хаяглах, хадгалалт хамгаалалтад анхааран ажиллах	Батлагдсан технологи заавар чанар Үйлдвэрлэлийн заавар Батлагдсан технологи заавар	Т Т Г,Т
3 дугаар зорилтын хүрээнд	- Тэжээлт орчин, будаг урвалж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигд явуулах бэлтгэл хангах. - Үндсэн түүхий эд болох элэг, цөс, нойр булчирхай, гахайн ходоод, тархи, махыг технологийн дагуу бэлтгэх - Тэжээлт орчин үйлдвэрлэхэд ашиглагдсан химийн шил сав, хувин тогоо шүлтийн даавууг угааж дараагийн ажил эхлэхэд бэлэн болгох	Арга зүй, удирдлагаас өгсөн чиг үүрэг Түүхий эд бэлтгэх заавар Үндсэн тэжээлт орчин бэлтгэх САЗ	Г Г,Т Г
4 дугаар зорилтын хүрээнд	- Үйлдвэрлэсэн тэжээлт орчин, будаг урвалж уусмал будаг шингээсэн цаасны нөөцийг 14 хоногт нэг удаа гаргаж тасгийн холбогдох мэргэжилтэнүүдэд танилцуулах - Био үйлдвэрлэлийн лабораторийн тэжээлт орчин, будаг урвалж уусмал, будаг шингээсэн цаас үйлдвэрлэлд шаардлагатай бараа материалын захиалгыг бага эмчид гаргаж өгөх - Үйл ажиллагааны тоон мэдээг үнэн зөв гаргах - АШБМаягтуудыг цаг тухай бүр нь бүрэн хөтлөх, тоног төхөөрөмжийн ажилласан цагийн бүртгэлийг бүртгэх	Нөөцийн хэмжээг гаргах Бараа материалын захиалгыг гаргах Тоон мэдээг үнэн зөв гарагсан байх Холбогдох тушаал зааврын дагуу хөтлөх	Г Г Г Г
5 дугаар зорилтын хүрээнд	Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр чанарын баг болон алба тасгийн зүгээс явуулж буй үйл	Хамрагдсан сургалт, оролцсон	Т

	ажиллагаанд идэвхтэй оролцох, сургалтад хамрагдах - Ажлын байрны эрсдэл үүсч болох нөхцөл байдал, алдаа үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай заавар журмын дагуу авч хэрэгжүүлэх, мэдээлэх	ажлын тоо - Засаж сайжруулсан ажил үйлчилгээний тоо	T
6 дугаар зорилтын хүрээнд	- Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг мөрдөж ажиллах - Байгууллага болон алба, тасаг нэгжээс зохион байгуулж буй соёл, олон нийтийн арга хэмжээнд оролцох - Хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх	- Эрхзүйн баримт бичгүүдийг мөрдөн ажилласан байдал - Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал, тоо хэмжээ - Хуулийн чиглэлээр сургалтанд хамрагдсан тоо, үр дүн	Г ГТ Г
Ажлын үндсэн хариуцлага	1. Нийтийн ашиг сонирхлын зөрчил гаргахгүй ажиллах 2. Хуулийн хүрээнд удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь бүрэн чанартай хийж гүйцэтгэх 3. Ажлын цагийг баримтлан ажиллаж, үр бүтээлтэй ажиллах 4. Ариутгал халдваргүйтгэл, био-үйлдвэрлэлийн тасгийн батлагдсан стандарт, САА, АЗ, журам зааврыг баримтлан үнэн зөв гүйцэтгэх 5. Өвчтөний мэдээллийн нууцыг хадгална. 6. Эмч эмчтэй харилцах, эмч эмнэлгийн ажилтнуудтай харилцах ёс зүйг баримтлан ажиллана. 7. Үйлдвэрлэлийн хэсгийн тоног төхөөрөмж, эд зүйлсийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллана.		
Ажил гүйцэтгэхэд олгосон эрх	1. Мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдаж өөрийгөө хөгжүүлэх 2. Тусламж үйлчилгээний чанар сайжруулах чиглэлээр талаар санал дэвшүүлэн шийдвэрлүүлэх 3. Байгууллагын тулгамдсан болон удаан хугацаанд шийдвэрлэхгүй байгаа асуудлын талаар санал боловсруулан удирдах ажилтанд танилцуулах 4. Тусламж үйлчилгээтэй холбоотой тоо, мэдээллийг шаардлагатай эх үүсвэрээс гаргуулан авах 5. Хийсэн ажлын үр дүнгээр урамшуулалд хамрагдах 6. Хэвийн бус нөхцлийн нэмэгдэл авах 7. Ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгсэлээр хангуулах		
Орлон хавсран ажиллах албан тушаал			
Шаардлагатай тохиолдолд бусад лаборант нарыг орлон буюу хавсран ажиллана.			

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА




Боловсрол	Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг лаборант, лабораторийн техникч, био-анагаах судлаач мэргэжлээр төгссөн.
Мэргэжил	Лаборант, лабораторийн техникч
Мэргэшил	Зоонозын өвчин судлалын тасралтгүй сургалтанд хамрагдсан байх
Туршлага	Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх.
Ур чадвар	- Харилцааны соёлтой, харилцааны чадвартай - Багаар ажиллах - Бүтээлч санаа дэвшүүлэх

	- Хэрэглээний програмуудыг эзэмшсэн байх. - Хариуцлага хүлээх - Ажлын байранд хөрвөж ажиллах
--	--

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:	
1. Албаны дарга 2. Биотехнологич 3. Биохимич	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Ариутгагч, Бэлдмэлчин	Бусад харилцах субъект 1. Салбар орон нутгийн ЗӨСТөв 2. Тухайн мэргэжлийн чиглэлээрх мэргэжлийн нийгэмлэг, холбоод 3. Төрийн болон төрийн бус бусад байгууллагагэх мэт

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан	Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан
Захирлын албан үүргийг хавсран гүйцэтгэгч Б.Амгаланбаяр  /гарын үсэг/ 2024 оны 09 сарын 05-ны өдөр	Хүний нөөцийн менежер Э.Пагмадулам  /гарын үсэг/ 2024 оны 09 сарын 05-ны өдөр
Албан тушаалын тодорхойлолт танилцуулсан	Албан тушаалын тодорхойлолттой танилцсан
Ариутгал, халдваргүйтгэл, биосүйлдвэрлэлийн албаны дарга Ц.Хишигжаргал  /гарын үсэг/ 2024 оны 09 сарын 05-ны өдөр	Лаборант Ш.Оюунцэцэг  /гарын үсэг/ 2024 оны 09 сарын 05-ны өдөр